

**УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ОРШИХ
“ПИ ЭС СИ” ХХК-ИЙН “ХИМИЙН БОДИС ИМПОРТЛОХ, ХУДАЛДААЛАХ,
ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**



**УЛААНБААТАР ХОТ
2025 ОН**

АГУУЛГА

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
1.1 Төслийн товч танилцуулга	4
1.2 Төслийн ерөнхий мэдээлэл	4
1.3 Төслийн талбайн байршил	5
1.4 Төслийн онцлог	5
1.5 Төслийн талбай орчмын газар ашиглалт, дэд бүтэц.....	6
1.6 Төслийн барилга байгууламжийн зохион байгуулалт.....	7
1.7 Ажиллах хүч ба хөдөлмөр хамгаалал	9
1.8 Төслийн нийгэм, эдийн засгийн үр өгөөж.....	10
ХОЁР. ДАРАЛТААР САВЛАСАН ХИЙНҮҮДИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ	11
2.1 Даралтат савтай хийнүүдийн ерөнхий мэдээлэл	11
2.2 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн.....	13
2.2.1 2025-2029 оны мод тарих төлөвлөгөө	13
ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	14
3.1 Эрх зүйн үндэслэл ба түүний гол шаардлага	14
3.2 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтууд.....	14
3.3 Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө.....	15
3.4 Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөө.....	25
3.5 Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	31
3.6 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	31
3.7 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	48
3.8 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	55
3.9 Байгаль орчны менежмент төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	57
3.10 Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	62
3.11 2025-2029 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал.....	63

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн ерөнхий мэдээлэл.....	4
Хүснэгт 2. Агуулахад хадгалагдан ашиглагдах химийн бодисын нэр томъёо, хэмжээ	12
Хүснэгт 3. 2025-2029 оны мод тарих төлөвлөгөө.....	17
Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	21
Хүснэгт 5. Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөөний биелэлт.....	25
Хүснэгт 6. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний биелэлт.....	31
Хүснэгт 7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	31
Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	48
Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.	55
Хүснэгт 10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт.....	57
Хүснэгт 11. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт.....	62
Хүснэгт 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	63

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн товч танилцуулга

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах ХБНГУ-ын 100%-ийн хөрөнгө оруулалттай “Пи Эс Си” ХХК нь 2004 оны 4-сарын 8-нд байгуулагдсан ба Лихтенштайн улсын “Hilti”, Швейцарийн улсын “Leica”; ХБНГУ-н “Draeger”, “Testo” зэрэг фирмүүдийн барилга, уул уурхайн зориулалттай багаж болон хувь хүний хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны багаж, тоноглол хэрэгслүүд, бусад барилгын холбогдолтой бүтээгдэхүүнүүдийг импортолж, худалдан борлуулах үйл ажиллагааг явуулдаг.

Төсөл хэрэгжүүлэгч нь уурхай, үйлдвэр зэрэг эрсдэлтэй нөхцөлд ажиллагсдын хувь хүний ажлын аюулгүй орчин, хөдөлмөр хамгаалалтад зориулагдсан аливаа хорт хий, агаарын болон хүчилтөрөгчийн дутмаг орчныг урьдчилан мэдрэгч, илрүүлэгч олон төрлийн багажуудыг импортлон дотооддоо борлуулах үйл ажиллагаа явуулдаг. Тэдгээр багажуудад 6 сараас 1 жил тутамд тохиргоо хийгдэх зайлшгүй шаардлагатай байдаг ба үүнд нэн хэрэгцээтэй багажийн үйл ажиллагааг хянах, тохируулах зориулалттай (Calibration gas) тест хийнүүдийг импортолж борлуулах хэрэгцээ шаардлага үүссэн. Иймд компанийн зүгээс 26 нэр төрлийн даралтаар савлагдсан хий болон нүүрсхүчлийн хий шингээгч шохойн чулууг импортлон, худалдаалах явцдаа хүрээлэн буй орчин, хүн амд хор аюулгүйгээр үйл ажиллагааг явуулах нь чухал юм.

Төсөл нь одоогийн байдлаар 20 ажилтантай өөрийн эзэмшлийн 3 давхар үйлчилгээний байртай бөгөөд нэг давхарт нь хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах болон бусад барилгын багаж хэрэгсэл борлуулах дэлгүүр ажиллуулж байна.


1.2 Төслийн ерөнхий мэдээлэл

Хүснэгт 1. Төслийн ерөнхий мэдээлэл

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ	“Пи Эс Си” ХХК Улсын бүртгэлийн дугаар: 9019021042 Регистрийн дугаар: 2822733 Хаяг: Улаанбаатр хот, Хан-уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, 72/01 Тусгай зөвшөөрлийн дугаар: 0000317
ТӨСЛИЙН НЭР	“Химийн бодис импортлох, худалдаалах, ашиглах химийн бодисын агуулах”
ТӨСЛИЙН ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ	Тус компани нь уурхай болон үйлдвэрүүдэд ашиглагдах хувь хүний ажлын аюулгүй орчин, хөдөлмөр хамгаалалд зориулагдсан аливаа хорт хий, агаарын болон хүчилтөрөгчийн дутмаг орчныг урьдчилан мэдрэгч, илрүүлэгч олон төрлийн багажуудыг импортлон дотооддоо борлуулах үйл ажиллагаа явуулдаг. Тэдгээр багажуудад 6 сараас 1 жил тутамд тохиргоо хийгдэх зайлшгүй шаардлагатай байдаг ба үүнд нэн хэрэгцээтэй багажийн үйл ажиллагааг хянах, тохируулах зориулалттай (Calibration gas) тест хийнүүдийг импортолж борлуулах хэрэгцээ шаардлага үүссэн. Иймд компанийн зүгээс 26 нэр төрлийн даралтаар савлагдсан хий болон нүүрсхүчлийн хий шингээгч шохойн чулууг импортлон, худалдаалах явцдаа хүрээлэн буй орчин, хүн амд хор аюулгүйгээр үйл ажиллагааг явуулах нь чухал юм.

1.3 Төслийн талбайн байршил

Төсөл хэрэгжүүлэгчийн үндсэн үйл ажиллагаа явуулдаг оффис, бараа бүтээгдэхүүний дэлгүүр нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт 1012 м² газарт, химийн бодисын агуулах нь тухайн газрын замын баруун урд 1311 м² газарт байрлана.



Зураг 1. Төслийн байршил

1.4 Төслийн онцлог

ХБНГУ-ын 100% -ийн хөрөнгө оруулалттай “Пи Эс Си” ХХК нь уурхай, үйлдвэр зэрэг эрсдэлтэй, хязгаарлагдмал орчин нөхцөлд ажиллагсдын хувь хүний ажлын аюулгүй орчин, хөдөлмөр хамгаалалтад зориулагдсан аливаа хорт хий, агаарын болон хүчилтөрөгчийн дутмаг орчныг урьдчилан мэдрэгч, илрүүлэгч олон төрлийн багажуудыг импортлон дотооддоо борлуулах үйл ажиллагаа явуулдаг. Тэдгээр багажуудад 6 сараас 1 жил тутамд хяналт тохиргоо хийгдэх зайлшгүй шаардлагатай байдаг ба үүнд нэн хэрэгцээтэй багажийн үйл ажиллагааг хянах, тохируулах зориулалттай “Calgaz” үйлдвэрийн (Calibration gas) тест хийнүүдийг импортлож борлуулах хэрэгцээ шаардлага үүссэн.

Мөн төсөл хэрэгжүүлэгч нь нүүрстөрөгчийн давхар ислийг (CO₂) шингээх зориулалттай бүтээгдэхүүн болох шохойн чулуу (Drägersorb 400) –г захиалагчийн хэрэгцээнд шаардлагатай хэмжээгээр импортлон борлуулдаг. Шохойн чулууны химийн

найрлагад кальцийн гидроксид ($\text{Ca}(\text{OH})_2$:78-84%), натрийн гидроксид (NaOH :2–4%) байна.

Иймд компанийн зүгээс 26 нэр төрлийн даралтаар савлагдсан хий болон нүүрсхүчлийн хий шингээгч шохойн чулууг импортлон, худалдаалах явцдаа хүрээлэн буй орчин, хүн амд хор аюулгүйгээр үйл ажиллагааг явуулах нь чухал юм.

Төсөл хэрэгжүүлэгчийн импортлон, борлуулдаг “Calgaz” даралтат хий үйлдвэрлэгч нь 45 гаруй жил үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд бүтээгдэхүүнүүд нь ISO 9001:2015 болон ISO/IEC 17025:2017 стандартуудын дагуу үйлдвэрлэгддэг.

Төсөл хэрэгжүүлэгч “Пи Эс Си” ХХК нь дээрх бүтээгдэхүүнүүдийг хэрэглэгчдийн захиалсан хэмжээгээр импортлон нийлүүлдэг бөгөөд эдгээр бодисуудын жилд импортлох хэмжээ нь хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээнээс хамааран янз бүр байдаг.

Эдгээр даралтат хийнүүдийг импортлохдоо агаарын тээврээр тээвэрлэдэг бөгөөд Чингис хаан олон улсын нисэх буудал дахь карго терминалаар нэвтрүүлдэг.

1.5 Төслийн талбай орчмын газар ашиглалт, дэд бүтэц

Газар ашиглалт. Тухайн төсөл хэрэгжиж буй газар нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн хойд хэсэгт буюу Дунд голын эрэг дагуу баруунаас зүүн тийш хэвтээ тэнхлэгийн туслах замын дагуу үйлдвэрлэлийн бүсэд байрлах ба энэ орчимд зөвхөн үйлдвэрлэл, аж ахуйн зориулалтаар байгууллагууд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд төсөл хэрэгжиж буй талбайн баруун талд “Витафит” ХХК-ийн үйлдвэр байрлах бол хойд талд нь Дунд гол урсаж байгаа бөгөөд баруун хойно “АПУ” ХХК логистик, “Говь” ХХК, “Гоёо” ХХК зэрэг компаниуд үйл ажиллагаагаа явуулж байна.

Дэд бүтэц. Уг төсөл нь Улаанбаатар хотын дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн үйлдвэрийн бүсэд хэрэгжиж буйгаараа онцлог юм. Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай дэд бүтцийн асуудлуудыг дараах байдлаар шийдсэн байна.

Цэвэр ус хангамжийн систем. Ажилчдын ундны усанд баллонтой ус авч ашигладаг. Оффисын бусад хэрэглээнд ашиглагдах усыг төвийн шугам сүлжээнээс авч ашигладаг. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын дагуу унд ахуйн хэрэглээний нормыг 1 хүний өдрийн 80 л-ээр тооцож гаргасан. Тухайн төслийн ашиглалтын жилүүдэд нийт 20 хүн, жилд 264 хоног буюу 5 жилд 1320 хоног ажиллахад нийт **2,157.9** м³ ус ашиглана. Гол хэрэглээ нь байгууллагын ариун цэврийн өрөөний ус байх бөгөөд 3 давхар оффисын цэвэрлэгээ, Аяга таваг угаагч, Ажилчдын хувцас угаах угаалгын машин, Үйлчилгээний машин угаалга зэрэгт усыг унд ахуйн зориулалтаар хэрэглэнэ.

Цахилгаан хангамж. Цахилгаан эрчим хүчний хэрэгцээг төвлөрсөн эх үүсвэрээс хангадаг.

Дулаан хангамж. Төвийн шугамын дулаан хангамж ашиглаж байна.

Тээвэр, харилцаа холбоо. Төслийн талбай нь Улаанбаатар хотод байршилтай тул бүх авто тээврийн хэрэгсэл ашиглагдах боломжтой бөгөөд төсөл хэрэгжиж буй газар нь авто

замын дагуу байрлана. Монгол улсад ашиглагддаг бүх харилцаа холбооны сүлжээг үйл ажиллагаандаа ашиглах боломжтой.


1.6 Төслийн барилга байгууламжийн зохион байгуулалт

Бараа бүтээгдэхүүнийг хэрэглэгчийн захиалсан хэмжээгээр импортолж оруулж ирдэг. Химийн бодис агуулдаг чингэлэг нь 18 м² талбайтай, 2.40 х 6.00 хэмжээтэй, 2.60 м өндөр, химийн бодист тэсвэртэй материалаар хийгдсэн шалтай, зохиомол гэрэлтүүлэгтэй, агааржуулагч болон утаа мэдрэгчтэй, 24 цагийн харуул хамгаалалттай. “Химийн хорт болон аюултай бодисын шошго анхааруулах тэмдэг” MNS 5029:2011 стандартад заасан анхааруулах болон аюулын тэмдэглэгээнүүдийг байрлуулсан, “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах, ерөнхий шаардлага” MNS 6458:2014 стандартын ерөнхий шаардлагыг хангасан.




Зураг 2. Химийн бодисын агуулахын байршил

Химийн бодис хадгалах байрыг 20 тн контейнерыг стандартын дагуу тоноглон тохижуулсан, орох гарах хаалтыг нэмэлтээр хийсэн, байгалийн гэрэлтүүлэгтэй, агуулахын дулааныг цахилгаан халаагуураар шийдсэн, бетонон хашаатай, 24 цагийн харуул хамгаалалттай байна.



Зураг 3. Даралтат хий хадгалах чингэлэг



Зураг 4. Бараа бүтээгдэхүүн борлуулж буй дэлгүүр

1.7 Ажиллах хүч ба хөдөлмөр хамгаалал

Тус төсөлд 2025 оны 12 сарын байдлаар нийт 20 хүн хөдөлмөр эрхэлдэг. Шилдэг боловсон хүчинг нэг дор төвлөрүүлэн өндөр бүтээмж, ашигтай ажиллагаа, сэтгэл ханамж, хамт олны гаргасан амжилтыг дэмжиж ажиллаж байгаа нь төслийн удаан хугацаанд үр ашигтай ажиллах бололцоог бүрдүүлж байна.

Ажилчдын хөдөлмөр хамгаалал. “Пи Эс Си” ХХК нь бараа бүтээгдэхүүний ачилт, буулгалт, тээвэрлэлт зэргийн ажилчдыг хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцсаар тогтмол хангаж, хөдөлмөрийн дотоод журмыг ажилчид мөрдөж байгаа эсэхэд байнга хяналт тавин ажиллаж байна. Мөн ажилчдын эрүүл хооллолт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндэд байнга анхаарал тавин ажилладаг бөгөөд ажилчдын эрүүл

мэндийг дэмжин спорт заал барьж бий болгосон ба жил бүр эрүүл мэндийн үзлэгт зориулсан төсөв баталж урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулдаг.

1.8 Төслийн нийгэм, эдийн засгийн үр өгөөж

“Пи Эс Си” ХХК -ийн “Химийн бодис импортлох, худалдаалах, химийн бодисын агуулах” төсөл хэрэгжсэнээр нийт 20 хүний ажлын байр бий болох бөгөөд улсын төсөвт тодорхой хэмжээний төлбөр татвар, хураамж хэлбэрээр төлөгдөх эерэг нөлөөтэй.

Мөн уг төсөл нь аюулгүй ажиллагааны багаж хэрэгсэл импортлон дотоодын компаниудад нийлүүлэх үйл ажиллагааны улмаас барилга, уул уурхай болон хүнд үйлдвэрийн салбарт ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал хангагдаж улмаар тухайн төслийн тогтвортой үйл ажиллагаа явуулах таатай нөхцөл бүрдэнэ.

Хувь хүний хамгаалах хувцас, хэрэгслийг импортлон дотоодын Уул уурхай, үйлдвэрлэл, барилгын салбарын компаниудад нийлүүлдэг. Улмаар ажиллагсдийн хөдөлмөр аюулгүй байдлийн чанар нэмэгдэж осол эрсдлийн тохиолдох магадлал буурах эерэг нөлөөтэй.

Төслийн нэгжтэй хамтран ажиллан аж ахуй нэгж байгууллагуудтай уялдаатай ажиллаж, ААНБ-уудын орлого, эргэлтийг нэмэгдүүлэх боломжтой.

Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ нь нийт 6 бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр үнэлэхэд агаарын чанар, амьтны аймаг гадаргын болон газрын доорх ус, хөрс, ургамалан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл дунд, газрын хэвлийд үзүүлэх нөлөөгүй байна.

Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг стандарт, норм, дүрэм журам, тайланд тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжийг дагаж мөрдсөнөөр нөлөөллийг бууруулах, арилгах боломжтой юм.

Болзошгүй сөрөг нөлөөлөл: Даралтат хийн хадгалах горим горим зөрчигдөж үйл ажиллагааны үед тэсэрч, дэлбэрэх аюул үүсгэж байгаль орчин хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Мөн даралтат хийг тээвэрлэх үед машин техникийн бүрэн бүтэн байдлыг цаг тухайд нь үзлэг шалгалт хийгээгүй, эсвэл гадны нөлөөтэй гэнэтийн осол гарсны улмаас даралтат хий хадгалах сав задарч, цоорон бодис алдагдсан тохиолдол бодисын ангилал, шинж чанараас хамааран байгаль орчин, хүний эрүүл мэндэд эрсдэл үүснэ. Даралтат хийн сав баглаа боодол нь аюултай хог хаягдлын ангилалд хамаарах бөгөөд бөгөөд 2018 оны 11-р сарын 13-ны өдрийн А-429/257 дугаар тушаалаар батлагдсан "Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалт"-д орно. Иймд сав баглаа боодлын хаягдалд хайхрамжгүй хандаж зориулалтын бус байдлаар хадгалж, устгасан тохиолдолд хүрээлэн буй орчинд эрсдэл үүснэ.

ХОЁР. ДАРАЛТААР САВЛАСАН ХИЙНҮҮДИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

“Пи Эс Си” ХХК-ийн багажийн тохиргоог хянах, тохируулах үйл ажиллагаанд ашиглагдах химийн бодисын агуулахад хадгалагдах 26 нэр төрлийн даралтад савтай хийнүүд болон шохойн чулууны эрсдэлийн үнэлгээг “Их зос” ХХК-аар хийж гүйцэтгүүлсэн.

Энэхүү эрсдэлийн үнэлгээний хүрээнд “Пи Эс Си” ХХК-ийн үйл ажиллагаанд ашиглагдах химийн хорт болон аюултай бодис болох даралтат савтай хийнүүд болон тэдгээрийг хадгалах агуулахын эрсдэлийг үнэлж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үүссэн тохиолдолд авах арга хэмжээг тодорхойлохыг зорьсон болно.

2.1 Даралтат савтай хийнүүдийн ерөнхий мэдээлэл

“Пи Эс Си” ХХК-ийн агуулахад хадгалагдан борлуулагдах химийн бодис (26 нэр төрлийн хий, нүүрсхүчлийн хий шингээгч шохойн чулуу) -ын нэр томьёо, CAS дугаар ба хадгалагдах хэмжээг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 2. Агуулахад хадгалагдан ашиглагдах химийн бодисын нэр томьёо, хэмжээ

№	Нэр		Томьёо	CAS	Хэмжээ, тонн/жил
	Монгол	Англи			
1	Устөрөгч/агаар	Hydrogen in air	H ₂ /Air	1333-74-0	0.060
2	Хүхэрт устөрөгч/агаар	Hydrogen sulfide in nitrogen	H ₂ S/N ₂	7783-06-4	0.060
3	Азот	Nitrogen	N ₂	7727-37-9	0.06
4	Азотын оксид/азот	Nitrogen Monoxide nitrogen	NO/N ₂	10102-43-9	0.06
5	Азотын давхар исэл/азот	Nitrogen Dioxide in nitrogen	NO ₂ /N ₂	10102-44-0	0.06
6	Азотын давхар исэл/агаар	Nitrogen Dioxide in air	NO ₂ /Air	10102-44-0	0.06
7	Аммиак/азот	Ammonia in nitrogen	NH ₃ /N ₂	7664-41-7	0.06
8	Хүхрийн давхар исэл/азот	Sulfure Dioxide in nitrogen	SO ₂ /N ₂	7446-09-5	0.06
9	Хүхрийн давхар исэл/агаар	Sulfure Dioxide in air	SO ₂ /Air	7446-09-5	0.06
10	Нүүрс хүчлийн хий/азот	Carbon Dioxide in nitrogen	CO ₂ /N ₂	124-38-9	0.06
11	Нүүрс хүчлийн хий/агаар	Carbon Dioxide in air	CO ₂ /Air	124-38-9	0.06
12	Нүүрстөрөгчийн дан/азот	Carbon Monoxide in nitrogen	CO/N ₂	630-08-0	0.06
13	Нүүрстөрөгчийн дан/агаар	Carbon Monoxide in air	CO/Air	630-08-0	0.06
14	Хүчилтөрөгч/азот	Oxygen in nitrogen	O ₂ /N ₂	7782-44-7	0.06
15	Бутадиен/агаар	1,3-Butadiene in air	C ₄ H ₆ /Air	106-99-0	0.06
16	Изобутен/агаар	Isobutylene in air	C ₄ H ₈ /Air	115-11-7	0.06
17	Метан	Methane	CH ₄	74-82-8	0.06
18	Метан/азот	Methane in nitrogen	CH ₄ /N ₂	74-82-8	0.06
19	Метан/агаар	Methane in air	CH ₄ /Air	74-82-8	0.06
20	Согтолтын тун илрүүлэгч багажийн ажиллагааг хянагч хийн холимог/азот	Gas mixture in nitrogen	C ₂ H ₅ OH/ N ₂	64-17-5	0.06
21	Хлор/азот	Chlorine in nitrogen	Cl ₂ /N ₂	7782-50-5	0.06
22	Цианид илрүүлэгч багажийн ажиллагаа хянагч /азот	Cyanide in nitrogen	HCN/N ₂	74-90-8	0.003
23	Хлорт устөрөгч/азот	Hydrogen chloride in nitrogen	HCl/N ₂	7647-01-0	0.06

24	Фосфин/азот	Phosphine in nitrogen	PH_3/N_2	7803-51-2	0.06
25	Холимог хий/азот	Gas mixture in nitrogen	$\text{CH}_4, \text{H}_2\text{S}, \text{CO},$	7783-06-4 630-08-0	0.06
			$\text{CO}_2,$ O_2/N_2	124-38-9 74-82-8 7782-44-7 7727-37-9	
26	Холимог хий/азот	Gas mixture in nitrogen	$\text{CO}, \text{CO}_2,$ O_2/N_2	630-08-0 124-38-9 7782-44-7	0.06
27	Шохойн чулуу (нүүрсхүчлийн хий шингээгч)	Draegersorb (CO_2 Absorber)	$\text{Ca}(\text{OH})_2,$ $\text{NaOH},$ H_2O	1305-62-0 1310-73-2 7732-18-5	24.4
НИЙТ					25.903

“Пи Эс Си” ХХК нь 5 жилд 1.503 тонн 26 нэр төрлийн даралтат хий, 24.4 тонн нүүрсхүчлийн хий шингээгч шохойн чулууг агуулахад хадгалан зориулалтын дагуу түгээх болно.

2.2 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгч нь ногоон байгууламж цэцэрлэгжүүлэлт болон нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэхдээ тухайн бүс нутагт ургах чадвартай мод, бут тарихыг зорьдог.

2.2.1 2025-2029 оны мод тарих төлөвлөгөө

Хүснэгт 3. 2025-2029 оны мод тарих төлөвлөгөө

№	Тариалах газар	Тариалах модны төрөл	Тариалах модны тоо, ширхэг
2025 он	Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Түргэний гол дагуух "Ногоон хэрэм" зурваст	3-4 настай том гацуур	15
		Гацуурын суулгац	15
2026 он	Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Түргэний гол дагуух "Ногоон хэрэм" зурваст	Нарс мод	10
		Голт бор	10
		Агч мод, нүргүүс,	10
2027 он	Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Түргэний гол дагуух "Ногоон хэрэм" зурваст	Улиангар	15
		Улиас	15
2028 он	Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Түргэний гол дагуух "Ногоон хэрэм" зурваст	Голт бор	15
		Хайлаас	15
2029 он	Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Түргэний гол дагуух "Ногоон хэрэм" зурваст	Хайлаас	15
		3-4 настай том гацуур	15
5 жилд нийт		150	

2025-2029 оны мод тарих төлөвлөгөөнд Хан-Уул дүүргийн Засаг даргын

хэрэгжүүлж буй “ЭКО-ЭРҮҮЛ ДҮҮРЭГ” хөтөлбөрийг дэмжин Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Түргэний гол дагуух "Ногоон хэрэм" зурваст жилд 30 тооны мод тарихаар төлөвлөсөн.

Тухайн газар нь хурдны зам дагуу байрладаг тул техник хэрэгслийн дуу чимээ, хаягдал хий, тоосноос үүдэх хүрээлэн буй орчны бохирдлыг саармагжуулах үүднээс бохирдуулагч бодисыг өөртөө шингээж авах чадварыг харгалзан үзэж тариалах чухал юм.

ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

3.1 Эрх зүйн үндэслэл ба түүний гол шаардлага

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдэх бөгөөд байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгаж, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсаныг баримтлан БОМТ, ОХШХ-ийг боловсруулсан.

2.2 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтууд

Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтуудыг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнгүүд болон Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны уг төсөлд хийсэн ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагууд дээр үндэслэн тодорхойлсон.

“Химийн бодис импортлох, худалдаалах, химийн бодисын агуулах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2025-2029 оны төлөвлөгөөнд урьдчилсан байдлаар **62,410 мянган төгрөг** зарцуулахаар тусгасан. “Пи Эс Си” ХХК нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 5 жил тутамд нэмэлт тодотгол хийлгэх, төслийн цар хүрээ энэхүү үнэлгээнд авч үзсэн техник технологи, хүчин чадал өөрчлөгдсөн тухай бүр зохих журмын дагуу Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яаманд хандаж нэмэлт тодотгол хийлгэж ажиллах шаардлагатай.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласнаар төслийн үйл ажиллагааны явцад гарч болзошгүй сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх, нэгэнт бий болсон сөрөг үр дагаврыг бага гэлтгүй тухай бүр нь нөхөн сэргээх замаар төслийн байгаль орчинд ээлтэйгээр хэрэгжүүлэх бололцоотой юм.

Төслийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд (Төрийн мэдээлэл, 2012 оны 22 дугаар) аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан байна. Иймд дээрх хуулийн шаардлагын дагуу, төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлыг хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулсан.

3.3 Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Биелэлт
Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах				
1	Химийн бодис тээвэрлэдэг автомашиныг Авто тээврийн тухай хуульд зааснаар тээврийн хэрэгслийг техникийн үзлэг оношилгоонд жилд нэг удаа тогтсон хугацаанд хамруулж байх. Шаардлагатай тохиолдолд засвар үйлчилгээг тогтмол хийлгэх.	309000₮	Ачаа тээвэрлэдэг тээврийн хэрэгсэлд өвлийн тос шүүр сольж өвлийн үйлчилгээг хийлгэсэн.	100%
3	Химийн бодистой харьцан ажиллаж байгаа ажилчдад үүсэж болох эрсдэлээс сэргийлэх, хянах, хариу арга хэмжээ авах мэдлэг, дадлага өгөх сургалтанд хамруулах. Химийн бодисын аюулгүй ажиллагааны зааварчилгааг бэлтгэн өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг байх		2025 онд нийтдээ 7 удаагийн татан авалтаар 12,3кг хэмжээтэй 13 нэр төрлийн тест хийнүүд импортолсон байна. Бүтээгдэхүүнүүдийг хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнээс хамааран захиалсан хэмжээгээр импортлон нийлүүлдэг тул агуулахад хадгалагдах даралтад хийний хэмжээ 1-4кг хооронд, хадгалах давтамж тогтмол бус байдаг. Иймд өдөр тутам тэмдэглэл хөтлөх шаардлага үүсээгүй болно.	100%
4	Химийн бодис хадгалаж буй агуулахуудыг MNS 6458:2014 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, химийн хорт болон аюултай бодисын агуулахын стандарт шаардлага хангаж байгаа эсэхэд тогтмол хугацаанд хяналт тавьж (Тухайбал: агааржуулалт, температур, халаалт, цахилгаан, чийг, гэрэлтүүлэг, агуулахын бусад нөхцлүүд) зэргийн шалган өдөр бүр тогтмол тэмдэглэл хөтлөх			
5	Химийн бодисын агуулахын доторх зохион байгуулалтад хяналт тавьж дэлбэрэлт, гал түймэр болох эрсдэлээс сэргийлж ажиллах. БОННУ-ний тайлангийн 6 дугаар бүлэг хүснэгт 21, 22-т заасан хадгалах горимыг анхаарч үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.			
6	Ажилтнуудад химийн бодистой харьцах үеийн хувийн хамгаалах хэрэгслээр хангаж ажиллах	Тухай бүр	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан	100%
7	Хадгалагдаж буй даралтат хийнүүдийн хаягжилтыг шалгах, стандартын дагуу хаягжуулах		Химийн бодис тээвэрлэх, хадгалах, ашиглах, устгах	

8	Агуулахад хадгалагдаж буй бодисуудыг хүлээн авах, олгох ажиллагааг бүртгэлжүүлж, нэгдсэн бүртгэлийн систем үүсгэж ажиллах		үйл ажиллагааны нөлөөллийн зардалд тусгагдсан	
9	Даралтат хийн хадгалах горимыг баримтлах.			
10	Асгаралт алдагдал үүссэн үед тархалтыг тодорхойлж, тухайн орчинд ажиллаж буй ажилтнуудыг аюулгүй бүсэд гаргах, агаар сэлгэлтийг хийж, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээ авах.			
11	Гал түймэр үүссэн тохиолдолд бэлэн байдалд байх үүднээс галын хор, элс зэрэг гал унтраахад ашиглагдах хэрэгслүүдийг агуулах болон оффист байршуулах.		Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан	100%
Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах				
12	Хог хаягдлын цэгийг төвлөрсөн нэг цэгт байгуулж, Хог хаягдал ачиж тээвэрлэх гэрээ байгуулан, ахуйн хог хаягдал болон аюултай хог хаягдлыг устгуулах гэрээ хийж, гэрээний дагуу сар тутамд зөвшөөрөгдсөн хогийн цэгт хаях.	Төслийн талбай	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан	100%
13	Даралтат хийг тээвэрлэх үед машин техникийн бүрэн бүтэн байдлыг цаг тухайд нь үзлэг шалгалт хийх. Сав баглаа боодлын битүүмж зэргийг тогтмол шалгаж хаягжуулалт хийх.	Тухай бүр	Ачаа болон химийн бодисыг тээвэрлэдэг тээврийн хэрэгслийг техникийн үзлэг оношилгоонд жилд нэг удаа тогтсон хугацаанд хамруулдаг.	100%
14	Импортлогдсон даралтат хийг зориулалтын бус байдлаар ашиглагдахаас сэргийлж найдвартай байгууллага, хувь хүнд борлуулах.		--*--	100%
15	Болгоомжгүй байдлаар асгаралт үүсэн хөрс нь бороо хурын усаар угаагдан ургамлан орчинд бохирдол үүсгэж, үржил шимийг бууруулах эрсдэлтэй. Иймд асгаралтын үед авах төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай.	250,000₮	Төслийн байрлаж буй талбай бүхэлдээ хатуу хучилттай. Хадгалагдаж буй химийн бодисууд нь тохиргооны хийнүүд тул хий асгарах хөрс бохирдуулах эрсдэл үүсээгүй. Ямарваа байдлаар тээврийн хэрэгслийн түлш шатахуун болгоомжгүй байдлаар асгарсан тохиолдолд шингээх зулхай материал бэлдсэн байгаа.	100%
Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах				

16	Тээвэрлэлт, хадгалалт, ашиглалтын явцад сав баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгах.	Тухай бүр	Тээвэрлэх хадгалахдаа цилиндрүүдийг үргэлж босоо байрлалд хадгалдаг. Унах гэмтэхээс хамгаалсан төмөр хийцлэлтэй хамгаалалтын хайрцагт байршуулдаг.	100%
17	Ажлын талбайд болгоомжгүй байдлаар асгаралт үүсэн хөрс, бороо хурын усаар дамжин гадаргын болон гүний усанд бохирдол үүсгэж болзошгүй. Иймд асгаралтын үед авах төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай	“Пи Эс Си” ХХК-н ажлын байр	Төслийн байрлаж буй талбай бүхэлдээ хатуу хучилттай. Хадгалагдаж буй химийн бодисууд нь тест хийнүүд тул хий асгарах хөрс бохирдуулах эрсдэл үүсээгүй.	100%
18	Унд ахуйн хэрэглээ, ногоон байгууламжинд ашиглагдаж байгаа усны өдрийн норм хэмжээг хэтрүүлэн хэрэглэхгүй байх хэмнэлттэй ашиглах тал дээр анхаарч ажиллах, усны хэрэглээг тоолууржуулах.		Цэвэр усны шугамд усны тоолуур суурилуулсан ба хэрэглээгээ сар бүр хянаад явдаг.	100%
Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах				
19	Химийн бодисоор бохирдох, устах Болгоомжгүй байдлаар асгаралт үүсэн хөрс нь бороо хурын усаар угаагдан ургамлан орчинд бохирдол үүсгэж, үржил шимийг бууруулах эрсдэлтэй. Иймд асгаралтын үед авах төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай.	Төслийн талбай	Химийн бодис тээвэрлэх, хадгалах, ашиглах, устгах үйл ажиллагааны нөлөөллийн төлөвлөгөөний зардалд тусгагдсан	100%
20	Төслийн талбайн ногоон байгууламж, мод бутны арчилж тордох		Төслийн талбайд тарьсан бутнуудыг тогтмол усалж байсан. Жилд 1 удаа таналт хийдэг.	100%
Химийн бодис тээвэрлэх, хадгалах, ашиглах, устгах үйл ажиллагааны нөлөөлөл				
21	Ажилтнуудад химийн бодистой харьцах үеийн хувийн хамгаалах хэрэгслээр хангаж ажиллах		Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан	100%
22	Химийн бодистой харьцан ажиллаж байгаа ажилчдад үүсэж болох эрсдэлээс сэргийлэх, хянах, хариу арга хэмжээ авах мэдлэг, дадлага өгөх сургалтанд хамруулах. Химийн бодисын аюулгүй ажиллагааны зааварчилгааг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг байх.	3,284,988₮	Химийн бодистой харьцан ажилладаг нийт 4 ажилтанд UTC сургалтын төвтэй хамтран химийн аюултай болон хортой бодисын аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулсан.	100%

23	Химийн бодис хадгалаж буй агуулахуудыг MNS 6458:2014 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, химийн хорт болон аюултай бодисын агуулахын стандарт шаардлага хангаж байгаа эсэхэд тогтмол хугацаанд хяналт тавьж (Тухайбал: агааржуулалт, температур, халаалт, цахилгаан, чийг, гэрэлтүүлэг, агуулахын бусад нөхцлүүд) зэргийн шалган өдөр бүр тогтмол тэмдэглэл хөтлөх	Химийн бодис хадгалах агуулах,	Химийн бодис хадгалах тээвэрлэхдээ үргэлж босоо байрлалд хадгалж тээвэрлэдэг. Нарны тусгалгүй, агааржуулалттай, ердийн температурт хадгалдаг.	100%
24	Даралтат хийг хадгалахдаа цахилгааны монтаж, тос тосолгооны материал зэргээс хол байршуулах			
25	Хий алдагдаж хуримтлагдахаас сэргийлж, хуримтлал үүсгэх байрлалуудын шалгах.			
26	Химийн бодисын агуулахын доторх зохион байгуулалтад хяналт тавьж дэлбэрэлт, гал түймэр болох эрсдэлээс сэргийлж ажиллах. БОННУ-ний тайлангийн 6 дугаар бүлэг хүснэгт 21, 22-т заасан хадгалах горимыг анхаарч үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.			
27	Хадгалагдаж буй даралтат хийнүүдийн хаягжилтыг шалгах, стандартын дагуу хаягжуулах			
28	Агуулахад хадгалагдаж буй бодисуудыг хүлээн авах, олгох ажиллагааг бүртгэлжүүлж, нэгдсэн бүртгэлийн систем үүсгэж ажиллах			
29	Даралтат хийн хадгалах горимыг баримтлах. (исэлдүүлэгч шинж чанартай бодистой хамт хадгалж болохгүй гэх мэт.)			
30	Асгаралт алдагдал үүссэн үед тархалтыг тодорхойлж, тухайн орчинд ажиллаж буй ажилтнуудыг аюулгүй бүсэд гаргах, агаар сэлгэлтийг хийж, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээ авах.			
31	Нийлүүлэгч компанийн ажилтан даралтат хийг худалдан авч буй байгууллага, хувь хүн бүрт даралтат хийг борлуулахдаа ашиглалт, тээвэрлэлт, хадгалалтын зааварчилгааг өгөх. Мөн сав баглаа боодлыг хадгалах зааварчилгааг өгөх. Ашиглагдаагүй болон үлдэгдэл хийг устгах зайлуулах оролдлого хийж болохгүйг анхааруулах.	Тухай бүр	Тест хийг худалдан борлуулах бүртээ ХАЛМ-ыг хэвлэж дагалдуулж өгдөг.	100%

32	Гал түймэр үүссэн тохиолдолд бэлэн байдалд байх үүднээс галын хор, элс зэрэг гал унтраахад ашиглагдах хэрэгслүүдийг агуулах болон оффист байршуулах.	503800₮	Галын хор нэмж авч байршуулсан.	100%
Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний нийт зардал			3,593,988.0	



Зураг 5. Гүний уурхайн аврагчдын амь хамгаалах, хорт хий хэмжих багажинд тохиргоо хийдэг



Зураг 6. Унах гэмтэхээс хамгаалсан төмөр хийцлэлтэй хамгаалалтын хайрцагт байршуулдаг байдал



Зураг 7. Цэвэр усны шугам дээрх усны тоолуур

Автомашин ашиглалтын паспорт /Car use passport

№	1. Техникийн тодорхойлолт/Technical description
1	Улсын дугаар/License plate number: 2883УКМ
2	Загвар/ Model Nissan Vanette
3	Ангилал,хөдөлгүүрий багтаамж/category,Engine displacement B, 1600
4	Бүх жин/Gross vehicle weight
5	Даац/ээлхүүн/суудлын тоо /Loading capacity, number of seats
6	Төрөл/Type
7	Зориулалт/Designation ачааны
8	Үйлдвэрлэсэн огноо/date of manufacture 2013
9	Хөдөлгүүрийн дугаар/Engine number
10	Арлын дугаар/VIN No: VM20043122
11	Өнгө/Color Цагаан/White
12	Импортлосон огноо/Date of import: 2024-11 cap
13	Өмчлөгч/Owner: Апитюд ХХК

2. Автомашинны дагалдах хэрэгслүүд /Car accessories

№	Дагалдах хэрэгслийн нэрц /Name of accessories	Тоо хэмжээ/Quantity
1	Галын хор/Fire extinguisher	1 ✓
2	Анхны тусламжийн хайрцаг/First aid kit	1 ✓
3	Ослын гурвалжин тэмдэг/Emergency triangle	1 ✓

3. Техникийн үзлэг, үйлчилгээний тэмдэглэл /Technical inspection and service records

Огноо Date	Ямар үйлчилгээ хийсэн What kind of service	Эвдэрэл гэмтэл,засварын тухай Сольсон салбар About damage and repair Replaced parts	КМ заалт Odometer	Үзлэг үйлчилгээ хийсэн хүний нэр Name of the person who performed the inspection	Гарын үсэг Signature
2025 03-10	GPS -тавиулаах	GPS тавиулаах	190526		Анжир
2025 10/23	Өвчин дугуйн солонх	Өвчин дугуйн солонх	194546		Анжир
2025 10-29	SW-30 MANNOL тос. шуур солонх	Өвчин тос шуур солонх	194662		Анжир

Тээврийн хэрэгсэл

Улсын дугаар 2883УКМ
Загвар NISSAN NV200
Үйлдвэрлэсэн он 2013

Үндсэн цэс

Техникийн хяналтын үзлэгийн мэдээлэл

- 🕒 Үзлэгт орсон огноо 2025/11/06
🕒 Үзлэгт дахин орох огноо 2026/11/06
📄 Тэнцсэн эсэх ✔ Тэнцсэн

Автомашин ашиглалтын паспорт /Car use passport

№	1. Техникийн тодорхойлолт/Technical description
1	Улсын дугаар/License plate number: 9145YEE
2	Загвар/ Model: Porter
3	Ангилал,хөдөлгүүрий багтаамж/category,Engine displacement: B, 2497
4	Бүх жин/Gross vehicle weight: 2680
5	Даац/эээлхүүн/сүүдлын тоо /Loading capacity, number of seats: 1000кг/3
6	Төрөл/Type: Ердийн тэвштэй
7	Зориулалт/Designation: Ачаа
8	Үйлдвэрлэсэн огноо/date of manufacture: 2006
9	Хөдөлгүүрийн дугаар/Engine number: KMFZCS7HP6U211529
10	Арлын дугаар/VIN No: Цагаан/White
11	Өнгө/Color: 2022-06-24
12	Импортлосон огноо/Date of import: Инка Централ Азия ХХК
13	Эмчлөгч/Owner:

№	2. Автомашины дагалдах хэрэгслүүд /Car accessories
1	Дагалдах хэрэгслийн нэрс /Name of accessories: Тогын хор/Fire extinguisher
2	Тоо хэмжээ/Quantity: 1
3	Анхны тусламжийн хайрцар/First aid kit: 1
4	Ослын гурвалжин тэмдэг/Emergency triangle: 1

3. Техникийн үзлэг, үйлчилгээний тэмдэглэл /Technical inspection and service records

Огноо Date	Авар үйлдвэрлэсэн What kind of service	Эмчилгээний үйлдвэрлэсэн About damage and repair Repaired parts	ХМ хэмжээ Odometer	Үйлчилгээний үйлдвэрлэсэн Name of the person who performed the inspection	Гарын үсэг Signature
2022 10-11	SW-40 машин масло, маслин шүүр солив.	Өвчин үйлчилгээ тос масло солих	149825	Нямсүрэн	Нямсүрэн
2022 10-21	Номин хөдөлгүүр 2м 2м 2м 2м солив.	Өвчин дүрвэ 2м 2м 2м 2м солив.	149540	Нямсүрэн	Нямсүрэн
2022 10-14	Тухайн үеийн сүлжээний.	Тухайн үеийн сүлжээ	149800	Нямсүрэн	Нямсүрэн
2023 11-07	Тос шүүр солих машин SW-40	Өвчин тос масло солих	155380	Нямсүрэн	Нямсүрэн
2024 01-26	Тангис, түрэг дүн, түрэг машин солив.	Тангис, түрэг дүн, түрэг машин солив.	158950	Нямсүрэн	Нямсүрэн
2024 02-26	Дээд салхинт нас засах ажил дот засварлав.	Дээд, кассетон машин тос тавих байдал засварлав.	157058	Нямсүрэн	Нямсүрэн
2024 11/05	SW-40 машин тос, тосны шүүр агаар шүүрэг солих.	Өвчин тос, шүүр агаар шүүрэг солих.	161186	Нямсүрэн	Нямсүрэн
2025 10-29	SW-30 машин тос шүүр солих.	Өвчин тос шүүр солих	167441	Нямсүрэн	Нямсүрэн

Тээврийн хэрэгсэл

Улсын дугаар **9145YEE**

Загвар **Hyundai Porter**

Үйлдвэрлэсэн он **2006**

Үндсэн цэс

Техникийн хяналтын үзлэгийн мэдээлэл

🕒 Үзлэгт орсон огноо **2025/07/03**

🕒 Үзлэгт дахин орох огноо **2026/07/03**

📄 Тэнцсэн эсэх **🟢 Тэнцсэн**

Зураг 8. Ачаа болон химийн бодис тээвэрлэдэг тээврийн хэрэгслийн үзлэг үйлчилгээ хийлгэсэн тэмдэглэл



ТӨЛБӨРИЙН БАРИМТ

ДДТД: 082000984929003094270031410010664

Борлуулагчийн:

ТТД: 2675366

НЭР: Авто-Ойл

Хаяг: Улаанбаатар, Сонгинохайрхан, 18-р хороо, null

Утас: 70070880

Огноо: 2025-10-29

Худалдан авагчийн:

ТТД: 2822733

Нэр: Пи Эс Си

Хаяг: Монгол, Улаанбаатар, Хан-Уул, 3-р хороо, ,

Үйлдвэрийн гудамж, 68/1

Утас: 75754584

Банкны нэр:

Банкны дансны дугаар:

Банкны IBAN дугаар: undefined

Д/Д	Бараа, ажил, үйлчилгээний нэр	Код	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд үнэ
1	Deluxe 90915-20001 тосны шүүр /TOY-VISTA,CAMRYMARK2,CROWN/		Нэгж	1	13,000	13,000
2	Deluxe 26300-42030-жижиг/ hyundai м.шүүр /GRACE 1ton PORTER,STAREX/		Нэгж	1	17,000	17,000
3	Deluxe MD-360935 митсубишн м.шүүр/ MIRAGE,LANGER,GLANT,DELICA,PAJERO/		Нэгж	1	11,000	11,000
4	Deluxe 87139-30040 Land-200 салон агаар		Нэгж	1	18,000	18,000
5	Deluxe 17801-31090 Land-200 агаар шүүр		Нэгж	1	25,000	25,000
6	Porter 2 агаар шүүгч		Нэгж	1	25,000	25,000
7	MANNOL-7511 Stahlsynth Energy 5w30 4л		Нэгж	3	56,000	168,000
8	MANNOL-7511 Stahlsynth Energy 5w30 1л		Нэгж	2	16,000	32,000



Бараа, ажил үйлчилгээний үнэ:

280,909.09

Нэмэгдсэн өртгийн албан татвар:

28,090.91

Нийслэл хотын албан татвар:

0

Нийт дүн:

309,000

Зураг 9. Тээврийн хэрэгслийн тос шүүр сольсон төлбөрийн баримт



ХИМИЙН ХОРТОЙ БА АЮУЛТАЙ БОДИСЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ СУРГАЛТЫН БҮРТЭЛИЙН ХҮҮДАС

Класс / Company: П-6-6, РК Сургалтын нэр/Course name: Hazardous Chemical Safety

Байр / Location: П-6-6, РК Огноо / Date (DD-MM-YYYY): 2025.12.10

Сургалтын багш / Instructor: S. Shreeganga Ургамал / Signature: S. Shreeganga Цаг / Time: 8

№	НЭР / FIRST NAME	ОВОР / LAST NAME	АЛБАН ТИШААЛ / POSITION	УТАСНЫ ДУЛААГ / PHONE	ТАРХИН ҮСЭГ / SIGN
1	Мундзай	Давдсдорж	Давдсдорж	99558534	Мундзай
2	Дорж	Батбаяр	Батбаяр	86098854	Дорж
3	Мундзай	Батбаяр	Батбаяр	99018574	Мундзай
4	Мундзай	Мундзай	Мундзай	99018574	Мундзай
5					
6					
7					
8					
9					
10					
11					
12					
13					
14					
15					
16					
17					
18					
19					
20					

СУРГАЛТЫН БАГШЫН (ТАРХИН ҮСЭГ) / INSTRUCTOR'S SIGNATURE: S. Shreeganga Огноо / DATE: 2025.12.10

UTC BN 01/01

Зураг 10. Химийн хортой болон аюултай бодисын аюулгүй ажиллагааны сургалтанд хамрагдсан байдал

3.4 Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 5. Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт
1	Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Түргэний гол дагуух "Ногоон хэрэм" зурваст “Пи Эс Си” ХХК-ийн төгөлд тарих.	2025 онд 35ш 3,650,000₮	Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Түргэний гол дагуух "Ногоон хэрэм" зурваст “Пи Эс Си” ХХК-ийн төгөлд 15 ширхэг 10 настай гацуур, 10 ширхэг 3-4 настай нарс тарьж суулгасан. Төслийн талбайн харьяа ХУД-ийн гуравдугаар хорооны захиргаанд 10 ширхэг шинэс мод хандивласан. Энгелсийн гудамжны нийтийн эзэмшлийн талбайд тарьж суулгасан.	100%
2	Төслийн талбайд тарисан 36 ш бургас	Тухай бүр	Төслийн талбайд тариалсан 36 ш бургас, ногоон байгууламжийн арчилгаа усалгааг тогтмол усалж тордож байсан.	100%
Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний нийт зардал			3,650,000.0	



Зураг 11. Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Түргэний гол дагуух "Ногоон хэрэм" зурваст 10 ширхэг 3-4 настай нарс тарьж суулгасан.



Зураг 12. Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Түргэний гол дагуух "Ногоон хэрэм" зурваст 15 ширхэг 10 настай гацуур, 10 ширхэг 3-4 настай нарс тарьж суулгасан.

Сангийн сайдын 2017 оны
347 дугаар тушаалын хавсралт



ТӨЛБӨРИЙН БАРИМТ

ЕВАРИМТ.MN

ДДТД: 191185021303000250522000001119489
 Борлуулагчийн:
 ТТД: ПИ85021303
 НЭР: УУГАН ЖАРГАЛСҮРЭН
 Хаяг: Монгол, Улаанбаатар, Хан-Уул, 20-р хороо, чингисийн
 өргөн чөлөө, 926, 66
 Утас: 88075849
 Банкны нэр:
 Банкны дансны дугаар:

Огноо: 2025-05-22
 Худалдан авагчийн:
 ТТД: 2822733
 Нэр: Пи Эс Си
 Хаяг: Монгол, Улаанбаатар, Хан-Уул, 3-р хороо, ,
 Үйлдвэрийн гудамж, 68/1
 Утас: 75754584

Д/Д	Бараа, ажил, үйлчилгээний нэр	Код	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд үнэ
1	Мод суулгац		ш	8	180,000	1,440,000
2	Мод суулгац		ш	7	150,000	1,050,000
Бараа, ажил үйлчилгээний үнэ:						2,490,000
Нэмэгдсэн өртгийн албан татвар:						0
Нийслэл хотын албан татвар:						0
Нийт дүн:						2,490,000



Сангийн сайдын 2017 оны
347 дугаар тушаалын хавсралт



ТӨЛБӨРИЙН БАРИМТ

ЕВАРИМТ.MN

ДДТД: 000002718944000250523000001190579
 Борлуулагчийн:
 ТТД: 2718944
 НЭР: Сосна
 Хаяг: Монгол, Сэлэнгэ, Ерөө, , Слентийн гудамж, 1
 Утас: 99256301
 Банкны нэр:
 Банкны дансны дугаар:

Огноо: 2025-05-23
 Худалдан авагчийн:
 ТТД: 2822733
 Нэр: Пи Эс Си
 Хаяг: Монгол, Улаанбаатар, Хан-Уул, 3-р хороо, ,
 Үйлдвэрийн гудамж, 68/1
 Утас: 75754584

Д/Д	Бараа, ажил, үйлчилгээний нэр	Код	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд үнэ
1	Гацуур (зул сарын) мод (тайрсан чимэглэлийн зориулалттай)	0324100	ш	10	40,000	400,000
Бараа, ажил үйлчилгээний үнэ:						363,636.36
Нэмэгдсэн өртгийн албан татвар:						36,363.64
Нийслэл хотын албан татвар:						0
Нийт дүн:						400,000



Зураг 13. Мод худалдаж авсан баримт



Зураг 14. Төслийн талбайн харьяа ХУД-ийн гуравдугаар хорооны захиргаанд 10 ширхэг шинэс мод хандивласан.
Энгельсийн гудамжны нийтийн эзэмшлийн талбайд тарьж суулгасан.

Сангийн сайдын 2017 оны
347 дугаар тушаалын хавсралт

EBARIMT.MN

ТӨЛБӨРИЙН БАРИМТ

ДДТД: 000005296625000250604000001810405

Борлуулагчийн:

ТТД: 5296625

НЭР: Ногоонхарш

Хаяг: Монгол, Улаанбаатар, Баянзүрх, 12-р хороо, 7, 110

Утас:

Банкны нэр:

Банкны дансны дугаар:

Огноо: 2025-06-04

Худалдан авагчийн:

ТТД: 2822733

Нэр: Пи Эс Си

Хаяг: Монгол, Улаанбаатар, Хан-Уул, 3-р хороо, ,

Үйлдвэрийн гудамж, 68/1

Утас: 75754584

Д/Д	Бараа, ажил, үйлчилгээний нэр	Код	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд үнэ
1	Жимсний үр суулгац	0136000	ш	1	760,000	760,000
Бариа, ажил үйлчилгээний үнэ:						760,000
Нэмэгдсэн өртгийн албан татвар:						0
Нийслэл хотын албан татвар:						0
Нийт дүн:						760,000



Хүлээн авсан: /...../

(гарын үсэг) (нэр)

Хүлээлгэн өгсөн: /...../

(гарын үсэг) (нэр)

Зураг 15. 10 ширхэг шинэс худалдаж авсан баримт

3.5 Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 6. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв хамгаалах арга хэмжээ		Хэрэгжилт	Биелэлт
1	Хэрэв цаашид төслийн хэрэгжилтийн явцад төслийн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор, ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомжид заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллагад нэн даруй мэдэгдэж арга хэмжээ авах шаардлагатай	Тухай бүрт	Төслийн хамрах хүрээнд түүх соёлын дурсгал одоогоор бүртгэгдээгүй байна.	100%
Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний нийт зардал			--	

3.6 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Тоо хэмжээ Нийт зардал /мян.төг	Тайлбар	Биелэлт
1. Гэнэтийн осол аваар				
1	Агуулахад хадгалах хийнүүдийн сав баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг ачиж буулгах, хадгалах үед байнга шалгаж байх. Гэмтсэн тохиолдолд нийлүүлэгчийн хариуцах ажилтанд мэдэгдэх;	Төслийн хүрээнд	Төсөл хэрэгжүүлэх хугацаанд сав баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдсан тохиолдол гараагүй.	100%
2	Аюул осол болон асгаралт алдагдал үүссэн үед ажилтнуудад хэрэглэх нэг удаагийн хамгаалах хувцас, бээлий, тусгай шүүлтүүр бүхий баг, нүд хамгаалах хэрэгсэл, каск, тусгай зориулалтын гутал зэргээр хангах	4,326,899₮	Ажилтнуудад шаардлагатай үед хэрэглэх хувцас, гутал, каск, маск хэрэглэл байнгын бэлэн байдалд бэлтгэн байрлуулсан. Бид ажилчиддаа өөрсдийн импортолж борлуулдаг	100%

	Механик эрсдлээс хамгаалах бээлий, химийн бүтээгдэхүүнээс хамгаалах EN 374 бээлий болон хамгаалалтын гутал хэрэглэх.		барилгын багажны Hilti брэндийнхээ Hilti логотой хувцас хэрэглэлээр жил бүр шинэчлэн хангадаг. 2025 оны 4 сард 234,4\$/836,777\$ (1\$=3569.87\$), 8 сард 680,89\$/2,446,710\$ (1\$=3593.4\$)-ын үнэ бүхий ажилчдын хувцас хамгаалалтын каск, хамгаалалтын шил захиалж авсан.	
4	Эмнэлгийн анхан шатны тусламжийн хайрцагт байх эм, хэрэгсэл материалуудаар хангах	45500\$	Анхан шатны тусламжийн хайрцагт эм нэг удаагийн амны маск нэмж авсан.	100%
5	Барилгын доторх цахилгаан тоног төхөөрөмж, гэрэлтүүлгийн угсралт, монтажйг шаардагдах стандартын дагуу хийж, тогтмол үзлэг шалгалт хийх	2025 онд	“Мега Ом инж” ХХК –аар жил бүр цахилгааны угсралт, тоног төхөөрөмжийн урсгал засварыг хийлгэдэг.	100%
3	Осол эрсдэл үүссэн үед хордлогод өртсөн хүнд анхны тусламж үзүүлэх аврах арга хэмжээний танхимын болон үзүүлэх сургалт зохион байгуулах	2025 онд	2025 оны 2 сарын 19-нд ХУД-ийн гал түймэр унтраах аврах 14 дүгээр ангитай хамтарсан гамшгаас урьдчилан сэргийлэх сургалтыг бүх ажилчдыг хамруулан зохион байгуулсан. ХУД-ийн Онцгой байдлын хэлтсийн гал түймэр унтраах, аврах 14 дүгээр ангиас “Гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөө”-г гаргаж баталж өгсөн.	100%
7	Болзошгүй гал түймрийн аюулаас урдчилан сэргийлэх үйл ажиллагаа, гал түймэр гарсан тохиолдолд авах арга хэмжээний төлөвлөгөө, зааварчилгаа зэргийг мэргэжлийн байгууллагаар хянуулан баталгаажуулж, тухайн объектын хариуцсан ажилтан, харуул, ажиллагсдад зааварчилгааг тогтмол өгч байх.			
8	Агуулахад тамхи татах, амархан гал авалцах эд зүйл (тосоор бохирдсон хувцас, алчуур, цаас г.м.) -ийг байршуулахыг хориглох; Ил гал, дөл гаргах, оч үсрэх төрөл бүрийн хэрэгслийг агуулахын орчинд ашиглахгүй байх тэмдэг тэмдэглэгээг байршуулах	Химийн бодисын агуулахын эргэн тойрон	Агуулахад ил гал гаргахыг хориглох тэмдэг байршуулсан. Тамхи татах цэгийг гадна орчинд бий болгосон. Тээврийн хэрэгслийн техникийн засвар үйлчилгээг авто засварын газарт нь хийлгэдэг. Иймээс техникийн засвар үйлчилгээнээс гарсан хаягдал тос масло, тосны шүүр, тосоор бохирдсон алчуур цаас гэх мэт хаягдал гардаггүй.	100%
9	Агуулахын барилгад галын дохиоллын систем суурилуулж, галын дохиоллын удирдлагын самбарыг 24 цагийн турш үүрэг гүйцэтгэх харуул хамгаалалтын өрөөнд байрлуулах	Төслийн хүрээнд	Объектод нийт 26 ширхэг галын дохиолол бий. Бүх өрөө тасалгаанд хяналтын камер суурилуулсан. 24 цагийн харуултай.	100%

2. Байгалийн гамшигт үзэгдэл				
10	Гал түймрээс хамгаалах, Аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага норм”-д заасны дагуу битүү агуулахын 200 м ² талбайтай тасалгаанд 1 ширхэг “дунд оврын” (5л -ээс 10 л хүртэл багтаамжтай) болон 2 ширхэг “бага оврын” (5л хүртэл багтаамжтай) гал унтраагуурыг байрлуулах.	Тухай бүр 806350₮	Оффис, дэлгүүр болон агуулахад галын хор, галын самбар анхны тусламжийн хайрцаг байрлуулсан. Агуулахын галын буланд Хүрз, Галын дэгээ, Хөрөө, Сүх, Царил, Хувин, Жоотуу, Элстэй сав (хайрцаг), Эсгий болон галд тэсвэртэй бүтээлэг, төрөл бүрийн гал унтраагуур, галын самбар гал унтраагуурын шалгах хуудас авч байрлуулсан.	100%
12	Байгалийн гэнэтийн аюул осолын үед авах арга хэмжээ, анхны тусламж үзүүлэх зэргийг сургалтын танхимаар болон үзүүлэх сургалтанд ажилчидыг хамруулах	2025 Бүх ажилчид 683,175₮	2025 оны 2 сарын 19-нд ХУД-ийн гал түймэр унтраах аврах 14 дүгээр ангитай хамтарсан гамшгаас урьдчилан сэргийлэх сургалтыг бүх ажилчдыг хамруулан зохион байгуулсан. Сургалтанд зориулж АИ92-10л, ДТ-10л худалдаж авсан.	100%
Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний нийт зардал			5,806,624.0	

Армон Хан-Уул

ТТД: 35900789790 ПOC: 107 2025.11.17 13:58
 №: 19 CAS: H24
 ДДТД: 035900789790107094460003310002350

ТТД: 2822733 **Худалдан авагч:**
 Нэр: Пи Эс Си

Бариа НӨАТ тооцох баримт	Т/ш	Нэгж Үнэ	Нийт Дүн
Налгезин 275мг №10, DD5672, 11/30/2028	10	1,080	10,800
Ризан №100, 24032, 12/1/2027	20	280	5,600
Цитрамон П №10 армон, 03012024, 0	20	80	1,600
Энап 5мг №20, 40982, 9/1/2027	10	250	2,500
Хуруу лент солонгос №1, 20240303, 0	100	50	5,000
Нийт: 25,500		Хөнгөлөлт: 0	
НӨАТ: 2,318.18		Төлөх дүн: 25,500.00	
		Хаан банк	
		Нийт төлсөн: 25,500.00	
		Хариулт 0.00	

Сугалаа:

ebarimt.mn-д
бүртгүүлэх дүн
25,500.00

Thank you for shopping
Powered by Infosystems POS System

Кард: 62345678901234567890
 Э/код: 12345678901234567890
 RBN: 007326091295
 Terminal: 70192178
Төлсөн дүн: 25,500.00
 Contactless TAP No Pin



ТӨЛБӨРИЙН БАРИМТ

ДДТД: 035900789790107094290003310002350
Борлуулагчийн:
 ГТД: 2019418
 ЧЭР: Ариунмонгол
 Хаяг: Монгол, Улаанбаатар, Чингэлтэй, 2-р хороо, 23, 31
 Утас: undefined

Огноо: 2025-10-31
Худалдан авагчийн:
 ТТД: 2822733
 Нэр: Пи Эс Си
 Хаяг: Монгол, Улаанбаатар, Хан-Уул, 3-р хороо, ,
 Үйлдвэрийн гудамж, 68/1
 Утас: 75754584

Банкны нэр:
 Банкны дансны дугаар:
 Банкны IBAN дугаар: undefined

Д/Д	Бариа, ажил, үйлчилгээний нэр	Код	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд үнэ
1	Маск нэг удаа энгийн №1		ш	40	500	20,000
